

**БАТЛАВ.
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**

Б.БАТ-ЭРДЭНЭ

**ОЙН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН
НАЙРУУЛГА/-ИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл.

Монгол Улсын Үндсэн хуулийн¹ Зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна.” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн” гэж тус тус заасан.

Алсын хараа-2050² Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилго 6-д “Байгаль орчинд ээлтэй ногоон хөгжлийг эрхэмлэн эко системийн тэнцвэрт байдлыг хадгалж, байгаль орчны тогтвортой байдлыг ханган үр өгөөжийг нь өнөө болон ирээдүй хойч үе хүртэх нөхцөлийг бүрдүүлж, хүний амьдралын чанарыг сайжруулна” гэж, уг бодлогын 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 6.1.3-т “Ой зохион байгуулалтыг тогтмол явуулж, ойн экосистемийн нөөц, төлөв байдлыг үнэлнэ.” гэж, 6.2.3-т “...ойн агро парк байгуулж, ашиглалтын нөөцийг бүсчлэн бий болгож байгалиас шууд авч ашиглах дарамтыг бууруулна.” гэж, 6.2.4-т “Ойжуулах, ойн тэлэн ургалтыг дэмжих, нөхөн сэргээх, ой хамгааллын арга хэмжээ авах замаар ойн хомсдолоос сэргийлэн, ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нийт газар нутгийн 9 хувьд хүргэж, нүүрсхүчлийн хийн шингээлтийг нэмэгдүүлнэ” гэж тус тус заасан байна.

“Шинэ сэргэлтийн бодлого”³-ын 5.1-д “Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад дорвитой хувь нэмэр оруулах зорилгоор “Тэрбум мод” үндэсний

¹ Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн,

² Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

³ Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоол “Төрийн мэдээлэл эмхтгэлийн 2021 оны 9 дугаарт нийтлэгдсэн,

хөдөлгөөнийг үр дүнтэй өрнүүлж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.” гэж тусгажээ.

Монгол Улсын Ерөнхийлөгч 2021 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 76 дугаар чуулган дээр Монгол Улс “Тэрбум мод тарьж ургуулах үндэсний хөдөлгөөн өрнүүлэх” болсныг зарлаж, мөн оны 10 дугаар сарын 4-ний өдөр “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 58 дугаар зарлиг гарсан. Уг зарлигт эх дэлхий, байгаль орчноо хайрлан зохицон амьдрах монгол уламжлал, зан заншлаа эрхэмлэн, дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, ой, усны нөөцийг хамгаалж, нэмэгдүүлэх экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг санаачлан өрнүүлэхийг дурдаж, зарлигийн 1.4-т “Цөлжилттэй тэмцэх, газрын доройтлыг бууруулах зорилгоор агро- ойг хөгжүүлж, иргэдийн амьжиргааны тогтвортой эх үүсвэрийг бий болгох, иргэн, аж ахуйн нэгжид татварын болон татварын бус бодлогоор дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчин бүрдүүлж, халамжаас-хөдөлмөрт шилжих цогц бодлоготой мод тарьж ургуулах бүх нийтийн үйлсийг уялдуулах” чиглэлийг өгчээ.

“Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн⁴ 86-д Ойн тухай хууль /шинэчлэн найруулга/-ийн төслийг боловсруулахаар тусгасан.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний⁵ 2.10-т “Модлог ургамлын үр, тарьц, суулгац бэлтгэх, импортлох, хадгалах, худалдан борлуулах, тээвэрлэх, ашиглах, үрийн нөөцийн улсын сан бүрдүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох”-оор заажээ.

“Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилт”⁶-ын хэрэгжилтийг хангуулахын тулд ойн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, ойн нүүрстөрөгчийн хийн шингээлтийг тооцох, түүнийг үнэлэх, тайлагнах эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

Түүнчлэн Ойн тухай хуулийг 2012 онд шинэчлэн баталснаас хойш 13 удаа нэмэлт, өөрчлөлт орсон, үүнээс 8 нь бусад хуулийг дагалдан орсон редакцийн шинжтэй нэмэлт, өөрчлөлт байна. 2022 онд орсон өөрчлөлтөөр улсын хэмжээнд ойн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагыг байгуулсан нь дэвшил байсан. Үүнээс өөрөөр ойн салбарын эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, ойг экосистемийн хувьд нь хадгалах, хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, ойн экосистемийн үйлчилгээнд бүрэн чиглэсэн ойн тогтвортой менежментийн бодлогыг урт хугацаанд хэрэгжүүлэхэд чиглэсэн агуулгын өөрчлөлт, шинэчлэлт хийгээгүй байна.

1.2. Практик шаардлага

⁴ Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоол, эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем [https:// legalinfo.mn/mn/detail?lawId=16389636270861](https://legalinfo.mn/mn/detail?lawId=16389636270861)

⁵ Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоол, эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем [https:// legalinfo.mn/mn/detail?lawId=17333392407821&type=3](https://legalinfo.mn/mn/detail?lawId=17333392407821&type=3)

⁶ Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 91 дүгээр тогтоол, [ЗОРИЛТ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ](#) ([Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилт](#))

2023 онд хийсэн Ойн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээгээр ойн салбарын нэр томъёоны тодорхойлолтыг олон улсын жишигт нийцүүлэх, Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд таримал ой бий болгох, мод тарьж ургуулах ажлыг урамшуулах, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхой болгох, ногоон эдийн засгийг дэмжих, ойн нүүрстөрөгчийн хийн шингээлтийг тооцож, олон улсын нүүрстөрөгчийн зах зээлд оролцох суурь нөхцөлийг бүрдүүлэх, ойн генетик нөөцийн талаарх зохицуулалтыг нарийвчлах, ойн салбарын удирдлагыг босоо тогтолцоонд шилжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатайг тогтоосон.

Улсын хэмжээнд 2014-2016 онд явуулсан олон зорилтод ойн тооллогын тайланд ойн нөөцийн 76 хувь нь болц гүйцсэн буюу хөгширсэн, унанги, ойн хөнөөлт шавж, өвчинд өртсөн талбай ихээр нэмэгдсэн, байгалийн жамаар нөхөн сэргэх чадамж буурсан, Монгол Улсын ойн үнэт чанар алдагдаж байна гэж дүгнэсэн.

"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд Монгол Улсын Засгийн газраас ойн хомсдол, доройтлыг бууруулан, ойгоор бүрхэгдсэн талбайг нэмэгдүүлэх зорилгоор нийт 1.5 тэрбум мод, сөөг тарьж, ойг нөхөн сэргээх болон таримал ойн талбайг нэмэгдүүлэх зорилт тавин ажиллаж байна. Энэ нь ойгоор бүрхэгдсэн талбайг нэмэгдүүлэхэд шинээр ой бий болгох, мод, сөөгийг тарималжуулах, ойн санд бүртгэх, өмчийн харилцааг нь тодорхой болгох зохицуулалтыг бий болгох хэрэгцээ байгааг харуулж байна.

Монгол Улсын хэмжээнд 46 ойн ангиас орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар 21, орон нутгийн төсөвт 20, улсын төсөвт үйлдвэрийн газар 4, төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар 1 байгаа нь эрх зүйн байдал, санхүүжилтийн хувьд ялгаатай нөхцөлийг бий болгож, ойн бодлого, ойн тухай хуулийг нэгдсэн удирдлагаар хангахад хүндрэл учирч байгаа тул өөрчлөх шаардлагатай байна.

Иймд хүн амын өсөлт, эдийн засгийн тэлэлттэй уялдан өсөн нэмэгдэж байгаа мод, модон бүтээгдэхүүний хэрэгцээг хангахад чиглэсэн ойн аж ахуйн арга хэмжээний төлөвлөлт, ойн зохистой ашиглалт, ойн экосистемийн тэнцвэртэй байдлыг хадгалах, хамгаалах, ойн сангийн ангилал, дэглэмийг шинэчлэн тодорхойлох, ойн тогтвортой менежментийн зарчмыг тусгах, ойн төлөвлөлт, хэрэгжилт, хяналт, шинжилгээ, үнэлгээ, төрийн хяналт шалтгалт, ойн салбарын босоо тогтолцоог бий болгох, ойн салбарын эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхой болгохтой холбоотой эрх зүйн орчныг сайжруулах шаардлага тулгарч байна.

Хоёр.Хуулийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Дээр дурдсан хуульзүйн үндэслэл, практик шаардлагад нийцүүлэн хуулийн зохицуулах харилцаа, хамрах хүрээ, агуулгад өөрчлөлт гарч, нийт заалтын тавиас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орж байгаа тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.2, 25.1.3 дахь заалтын дагуу хуулийн төслийг шинэчилсэн найруулгын төслийг боловсруулна.

Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зорилгыг Монгол Улсын ойн экосистемийн тэнцвэр, биологийн олон янз байдлыг хадгалах, ойн сан, түүний баялгийн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, тогтвортой ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино гэж томъёолно.

Энэ зорилгын хүрээнд хуулийн төсөлд зарчмын шинжтэй дараах харилцааг тусгана:

- Хуулийн үйлчлэх хүрээг өргөжүүлж, ойн салбарын зарим нэр томъёо, ойлголт, зарчмыг олон улсын жишигт нийцүүлэн, үндэсний онцлогийг харгалзан өөрчлөн найруулж, зарим шинэ нэр томъёог оруулах;
- Ойн бүсийн ангиллыг шинэчилж, тэдгээрт тохирсон дэглэмийн зохицуулалтыг нарийвчлах;
- Ойн тогтвортой менежментийн зарчмыг тусгаж, бүх шатны ойн менежментийн нийтлэг болон тусгайлсан (хушны самрыг биологийн нөөц болон ашиглалтын нөөцөд тулгуурлан тусгайлсан менежмент хэрэгжүүлэх) төлөвлөгөөг батлах, хэрэгжүүлэх, хяналт тавих зохицуулалтыг шинээр оруулах;
- Өөрийн хөрөнгөөр тарьж ургуулсан таримал ойг эзэмшиж ашиглах, үр шимийг хүртэх болон таримал ойг хүлээн авах, ойн мэдээллийн цахим системд бүртгэх, таримал ойгоор бүртгэснийг баталгаажуулж гэрчилгээ олгохтой холбогдсон харилцааг нарийвчлан зохицуулах;
- Ойн менежментийн үйл ажиллагаанд иргэд, орон нутгийн байгууллагын оролцоог хангах, экосистемийн үйлчилгээг хүртээмжтэй болгох, ой бүхий нутгийн иргэдийн давуу эрхийг тусгах;
- Ойн нөөцийн эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх, био эдийн засгийг хөгжүүлэх, дэмжихтэй холбогдсон зохицуулалтыг шинээр нэмэх;
- Ойг хамгаалах, нөхөн сэргээх, ойжуулах, агро ой аж ахуйг хөгжүүлэх, бүх нийтээр мод, сөөг тарихтай холбогдсон харилцааг нарийвчлан зохицуулах.
- Ойн нүүрстөрөгчийн шингээлтийг тооцох, ялгарлыг бууруулах, олон улсын нүүрстөрөгчийн зах зээлд оролцох боломжийг нээж, үүнтэй холбогдсон нүүрстөрөгчийн сангийн зохицуулалтыг шинээр заах;
- Нээлттэй ил тод байдлыг бэхжүүлэх зорилгоор ойн салбарыг цахимжуулах харилцааг шинээр тусгах.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал.

Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг батлан хэрэгжүүлснээр дараах ач холбогдол, эерэг үр дүн бий болгоно гэж үзэж байна. Үүнд:

- Ойн салбарын нэр томъёог олон улсын жишигт нийцүүлэн шинэчилснээр хуулийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх боломж бүрдэж, Монгол Улсын ойн сан бүхий газрын олон улсын болон дотоодын мэдээллийн сангийн зөрчил арилна.

- Ойг экосистемийг хадгалж, хамгаалах, нөхөн сэргээх, тогтвортой ашиглах бодлого хэрэгжиж, төрийн бодлогод дэвшүүлсэн зорилт хангагдана.

- Ойн салбарын удирдлага, зохион байгуулалт, тогтолцоо тодорхой болж, хууль үр дүнтэй хэрэгжих нөхцөл бүрдэнэ.

- Ойн нөөцийн эдийн засгийн үр өгөөж нэмэгдэж, ойн био эдийн засаг хөгжиж, ойн нэмэгдсэн өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл өргөжинө.

- Орон нутгийн иргэд ойн менежментийн төлөвлөгөөнд санал өгөх, түлээний болон ахуйн хэрэглээний зориулалтаар мод бэлтгэх, ойн дагалт баялаг ашиглах боломж баталгаажна.

- Нүүрстөрөгчийн зах зээлд оролцох зохицуулалт тодорхой болсноор ойн салбарын хөрөнгө оруулалт, санхүүжилт нэмэгдэх боломж бүрдэнэ.

- Ойн тогтвортой менежментийн зарчимд суурилсан ойн төлөвлөлт сайжирч, эрүүл ойг хадгалах, уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөлд одоо болон ирээдүй хойч үеийн нийгмийн сайн сайхан байдалд хувь нэмэр оруулах нөхцөл бүрдэнэ.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдсан байдал, уг хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн талаар.

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай нийцүүлэн боловсруулна.

Хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан Ойн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хууль, Ойн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Байгалийн ургамлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тариалангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулна.

--oOo--